



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГЫН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хуралдааны бүрэлдэхүүн томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан иргэн Д.Үүрцайх, Т.Доржханд, Г.Батаа болон О.Мөнхсайхан нарын мэдээллийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай асуудлаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж, нэгтгэн шалгахаар шийдвэрлэж Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго 2021 оны 11, 12, 13, 16 дугаар тогтоол гаргажээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Буяндэлгэр Үндсэн хуулийн цэцийн гишүүний дээрх тогтоолуудыг эс зөвшөөрч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар санал гаргасан байна. Уг саналыг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо хүлээн авч Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаанд бэлтгэх ажиллагааг гүйцэтгээд хуралдаанаар хэлэлцүүлэхээр товлож, тогтоол гаргасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны бүрэлдэхүүнд даргалагчаар Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр, гишүүдэд Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо /илтгэгч/, Ц.Нанзаддорж нарыг томилсугай.

2.Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг томилсугай.

ДАРГА



Н.ЧИНБАТ